

**Боловсрол, соёл, урлагийн газрын 7 хоногт  
хийсэн ажлын мэдээлэл**

**2018.01.11**

№	7 хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	Бусад асуудал
1	<p>Сурагчдын амралтаар ЕБСургуулиудын ахлах ангийн 30 сурагчийг ОХУ-ын Барнаул хотын Багшийн Их Сургуульд орос хэлний чадавхийг дээшлүүлэх долоо хоногийн сургалтанд хамрууллаа. БСУГ -ын дарга Х.Зауре, мэргэжилтэн У.Ботакөз, "Мир друзей" сургалтын төвийн захирал Х.Жулдыз нар тус сургуулийн удирдлагуудтай уулзаж багш, захиралуудыг Барнаул хотод сургалтанд хамруулах, туршлага солилцох үйл ажиллагааг хамтран зохион байгуулах талаар хэлэлцэж харилцан тохиролцов.</p>	<p>Аймгийн болон сумдын соёл урлагийн байгууллагуудын статистик мэдээг гаргаж УБ хотод Соёлын өвийн төвд хүргүүлэхээр бэлдэж байна.</p>	
2	<p>ХЭХ-2 төсөл нь БСУГ-тай хамтран нэгдсэн уулзалтыг 3 өдөр зохион байгууллаа.Уг уулзалтанд Ховд, Баян-Өлгий аймгийн ЭМГ, ГБХЗХГ-ын мэргэжилтэн, БСУГ-ын дотуур байр хариуцсан мэргэжилтэн болон загвар дотуур байрнуудын багш, нийгмийн ажилтнууд оролцож өнгөрсөн онд хийгдсэн үйл ажиллагааны талаар, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, чадавхжуулах сургалт зохион байгуулав.</p>	<p>2018 оны 01-р сарын 17-19-ний хооронд аймгийн төвийн болон сумдын ЕБС-ийн багш нарт сургалт явагдана.</p>	

3	<p>Аймгийн ЗДТГ, БСУГ, БТСГ-ын хамтран зохион байгуулсан ЕБС-ийн багш нарын анхдугаар "Спортын наадам-2018" амжилттай явагдаж өндөрлөлөө. Уг тэмцээнд 24 сургуулийн давхардсан тоогоор 1000-аад багш 7 төрлийн тэмцээнд авхаалж самбаа, хурд хүчээ сорин оролцож, нийлбэр дүнгээр Сагсай сумын БДС-ийн баг тамирчид 1-р байр эзэлж, Цом, Өргөмжлөл, 1,0 сая төгрөг, Өлгий сумын 5-р БДС-ийн баг тамирчид 2-р байр эзэлж Цом, Өргөмжлөл, 800,0 мянган төгрөг, Өлгий сумын 2-р БДС 3-р байр эзэлж Цом, Өргөмжлөл, 600,0 мянган төгрөгөөр тус тус шагнадав.</p>		
4	<p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, санал, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай 2-р улиралын мэдээг гаргаж ЗДТГ-д хүргүүлэв.</p>		
5			